

ЕРТӨНЦИЙГ ЯЛЖ, АМРАЛТЫГ ОЛОХ НЬ

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн ерөнхийлөгч

ЕСҮС ХРИСТ

ЭНЭ УНАСАН ЕРТӨНЦИЙГ
ЯЛЖ, БИДНИЙ

хүн нэг бүрийн төлөө Цагаатгалыг
гүйцэлдүүлсэн учраас гэм нүгэлд нэвчсэн,
хувиа хичээсэн, ихэнхдээ хэцүү бэрх энэ
ертөнцийг та нар бас ялж чадна.

.....



Хэрэв та үнэхээр наманчилж,
Түүний тусламжийг эрэлхийлбэл
өнөөгийн аюултай ертөнцийг
ялж амралтыг олж чадна.

БИД ЕРТӨНЦИЙГ ХЭРХЭН ЯЛАХ ВЭ?



Сүнсний
өдөөлтүүдийг
эрэлхийлж дагах



Өдөр бүр
наманчилж, хүч
өгдөг гэрээнүүдээ
сахих



Гэрээний зам
дээрээ үлдэх

2022 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс.

ЕРТӨНЦИЙГ ЯЛНА ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

Энэ нь:

- Бурханы зүйлээс илүү энэ ертөнцийн зүйлд санаа тавих уруу таталтыг ялан дийлэх,
- Хүмүүсийн гүн ухаанаас илүү Христийн сургаалд итгэх,
- Үнэнд баясаж, хууран мэхлэлтээс татгалзаж, "Христийн даруу дагалдагчид" болох,
- Сүнсийг холдуулах аливаа зүйлээс татгалзахыг сонгох, үйлддэг нүглээ хүртэл орхиход бэлэн байх
- Бурханыг болон Түүний Хайрт Хүүг хэнээс ч, юунаас ч илүү хайрладаг болохыг хэлнэ.



АВРАГЧ биднийг илүү их энэрэл, даруу байдал, өгөөмөр зан, нинжин сэтгэл, сахилга бат, амар амгалан болон амралтаар адислах замаар биднийг энэ унасан ертөнцийн таталтаас дээш өргөдөг.

**ЕСҮС ХРИСТ ЭНЭ ЕРТӨНЦИЙГ
ЯЛСАН ТУЛ ТА НАР Ч БАС ЯЛЖ ЧАДНА.**

